

**“ЭКО АЗИ” ДЭЭД СУРГУУЛЬД СУРГАЛТЫН
БАГЦ ЦАГИЙГ ХЭРЭГЛЭХ, МЭДЛЭГ ЧАДВАРЫГ
ҮНЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий ойлголт

1.1 Боловсрол, сүёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 158 дугаар тушаалаар батлагдсан “Дээд боловсролын зэрэг олгох сургалтанд багц цагийг хэрэглэх, сурагцагчдын мэдлэг чадварыг дүгнэх журам”-ыг үндэслэн боловсруулсан энэхүү журмыг “Эко-Ази” дээд сургуульд мөрдөн, оюутны мэдлэг, чадвар, дадлыг үнэлнэ.

Хоёр. Багц цаг, багц цагийг хэрэглэх

1.1 Нэг багц цагийн хэмжээ нь өдрийн хэлбэрээр суралцаж байгаа оюутны 7 хоногийн бүтэн ачаалал буюу 40 цагтай тэнцүү байна.

1.2 Тухайн хичээлийн багц цаг нь уг хичээлийг судлан эзэмшихэд суралцагчаас зарцуулах нийт хугацаа буюу уг хичээлийн танхимийн цаг /лекц, семинар/, суралцагчийн биеэ дааж ажиллах цаг /зөвөлгөө, ангийн ажил \төсөл\, реферат, график тооцооны ажил гэрийн даалгавар болон суралцагчийн мэдлэг чадварыг үнэлэх явцын үнэлгээнд зарцуулах нийт хугацааг өөртөө багтаана.

1.3 Нэг хичээлийн багц цаг 2-3 цаг байна.

1.4 Улирлын шалгалт, төгсөлтийн шалгалт багц цагт хамаарахгүй.

Хоёр.Оюутны мэдлэг, чадвар, үнэлгээний дүгнэлт

2.1 Оюутны мэдлэг, чадварыг үсгэн, тоон, процентэн үнэлгээр нэгээс нөгөөд шилжүүлэн үнэлнэ.

Үсгэн дүн	Тоон дүн	Процентэн дүн
À	4,0	90-100
Â	3,0	80-89
Ñ	2,0	70-79
D	1,0	60-69
F	0	0-59

A- тухайн хичээлийг бүрэн төгс ойлгосон, өргөн мэдлэг эзэмшсэн, уг хичээлийн агуулгыг чадварлаг эзэмшиж чадсан

B- хичээлийн агуулгыг сайн ойлгож эзэмшсэн, тухайн хичээлтэй холбоотой материалыг ашиглах, даалгавар хийж гүйцэтгэх чадвартай, эзэмшсэн мэдлэгээ зохих түвшинд үйл ажиллагаандаа хэрэглэх чадвар эзэмшсэн

C- Хичээлийн агуулгыг ихэнх хэсгийг сайн ойлгож эзэмшсэн, харьцангуй энгийн даалгаварыг хийж гүйцэтгэх чадвартай, цаашид энэ салбарын мэдлэгийг гүнзгийрүүлэн судлах нэмэлт даалгавар хийж гүйцэтгэх чадвартай

D- Хичээлийн агуулгыг жигд сайн ойлгоогүй, харьцангуй бага ойлголт авсан, ерөнхийдөө мэдлэг, чадвар дутмаг эзэмшсэн

F- Мэдлэг, чадвар, дадал хангалтгүй

2.2 Оюутныг үнэлэхдээ ирц, идэвхи, чармайлт, хичээлд бэлтгэсэн байдал, хийж гүйцэтгэсэн бичгийн ажил /ангийн ажил, реферат, илтгэл/ гэрийн даалгавар гэх мэт оюутны суралцах үйл ажиллагааны бүхий л талыг хамруулсан байна.

Гурав. Оюутны мэдлэгийн үнэлгээний шатлал

Оюутны мэдлэгийн үнэлгээний систем нь хоёр үе шаттай.

3.1.Тухайн хичээлийн үнэлгээ.

Тухайн хичээлээр оюутан эзэмшвэл зохих мэдлэгээ дүгнүүлэхийн тулд улирлын турш хэрхэн сурч хөдөлмөрлөснөө тухайн хичээлийг заасан багшаар 70 хүртэл оноогоор үнэлүүлнэ.

Тухайн хичээлийн үнэлгээг оюутны хичээлийн ирц идэвхи, бие даалт, явцын шалгалт зэрэг үзүүлэлтээс хамааруулж дүгнэнэ.

№	Ирц, идэвхи	Бие даалт	Явцын шалгалт
1	20	30	20

Явцын шалгалтыг багш улиралд 2-оос доошгүй удаа шалгаж үнэлгээг өгнө.

3.2 Улирлын шалгалтын үнэлгээ.

Эзэмшсэн мэдлэгийн түвшинг улирлын шалгалтын 30 хүртэл оноогоор тус тус үнэлүүлнэ.

3.3 Оюутны мэдлэг, чадвар, дадлыг үнэлэхдээ бичгээр /аман ярилцлага/ болон тестээр шалгалт авч үнэлнэ.

3.3 Хичээл заасан багш шалгалтыг авч, эцсийн үнэлгээг тооцон, оюутны сурлагын дэвтэр, дүнгийн хүснэгтэнд тэмдэглэн тухайн өдөртөө багтаан сургалтын албанд хүргүүлнэ.

Дөрөв. Суралцсан хугацааны агуулга эзэмшилтийн чанарын түвшин тогтоолт Суралцсан хугацааны агуулга эзэмшилтийн чанарын түвшинг тогтоохдоо голч дүнг гаргана.

Голч дүнг тухайн улирлын голч дүн, хуримтлуулсан голч гэж ангилна.

4.1 Улирлын голч дүн тухайн нэг улиралд судалсан хичээлүүдээс бүрдэнэ.

Улирлын голч дүнгийн тусламжтайгаар оюутан өөрийн сурлагын амжилтандаа дүн шинжилгээ хийж, сургалтын стандартын шаардлагыг хангаж байгаа эсэхээ хянах, цаашид суралцах арга барилаа төлөвлөнө.

Оюутны тухайн улирлын үнэлгээний голч дүн 1.7-оос доош бол уг оюутныг “Тухайн улиралд хангалтгүй суралцсан” гэж үзнэ. Оюутан 3 улирал дараалан хангалтгүй суралцсан бол уг оюутныг “сурлагаар тэнцэхгүй” гэж үзэж сургуулиас чөлөөлөх буюу төлбөртэйгээр давтан суралцуулна.

4.2 Хуримтлуулсан голч дүн нь сургалтын эхний жилээс эхлэн тодорхой улирлыг дуусталх хугацаанд судалсан хичээлүүдээс бүрдэнэ.

4.3 Голч дүнг гаргахдаа суралцагчийн тухайн хугацаанд судалсан хичээл бүрийн багц цагийг уг хичээлд авсан тоон дүнгээр харгалзуулан тус тусд нь үржүүлэн

хооронд нь нэмээд гарсан нийлбэрийг тухайн хугацаанд судалсан хичээлүүдийн багц цагийн нийлбэрт хуваана.

$$GPA = \frac{T_{д1} B_1 + T_{д2} B_2 + \dots + T_{ди} B_n}{B_1 B_2 + \dots B_n}$$

$T_{д1}, T_{д2}, \dots, T_{ди}$ – 1, 2, …, n дугаар хичээлүүдийг тоон дүн
 B_1, B_2, \dots, B_n -1, 2, …, n дугаар хичээлүүдийн багц цаг

Тав. Бакалаврын зэрэглэл олгох голч дүнгийн босго

5.1 Хуримтлуулсан голч оноо нь 2.3 хүрсэн нөхцөлд оюутанд бакалаврын зэргийн диплом олгоно.

5.2 Хуримтлуулсан голч оноо нь 2.3 хүрээгүй нөхцөлд оюутныг “Сонгосон мэргэжлээрээ хангалтгүй суралцсан” гэж үзэж бакалаврын зэргийн диплом олгохгүй.

5.3 Бакалаврын зэргийн диплом олгогдоогүй оюутанд жилийн чөлөө олгож дараагийн хичээлийн жилд хичээлийг төлбөртэйгээр дахин судлуулна.